



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.05.15 № A-1/2031

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД**

Тус газраас зарласан ЗТХЯ/20240101019 дугаартай XV.1.1.95 "Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Арвайхээр-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат /Өвөрхангай/" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирүүлсний дагуу захиалагч Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: .... хуудастай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324030468





ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251  
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,  
Цахим шуудан: info@mrtд.gov.mn,  
Цахим хуудас: www.mrtд.gov.mn

2024-05-10 № 03/2026  
танай 2024-05-03 -ны № А-1/1906 -Т

**Тодруулга хүргүүлэх тухай**

Танай байгууллагын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А-1/1900 дугаар албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт "Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын XV.1.1.95-д туссан Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Арвайхээр-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат (Өвөрхангай)" төсөл, арга хэмжээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн асуулгад дараах тодруулгыг хүргүүлж байна. Үүнд:

Тус яамны захиалгаар 2021 онд боловсруулсан "Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн 487,73 км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл"-өөс 2024 оны Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад туссан төсвийн хэмжээнд тааруулан зураг төсөл боловсруулсан зөвлөх компани "Эм Си Пи Си Жи Ар" ХХК-аар ажлын тоо хэмжээ салгах, төсвийг хэсэгчлэн хуваах ажлуудыг гүйцэтгүүлэн "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-аар 2024 онд 28/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргуулан баталгаажуулж хүргүүлсэн тул 24/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтэд туссан ажлын тоо хэмжээг мөрдөнө.

28/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтэд "Арвайхээр-Мандалговь чиглэлийн хэвтээ тэнхлэгийн 2.61 км авто зам болон Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замтай нийлэх 2 түвшний уулзварын барилгын ажлын төсөв" туссан тул ажлын зураг төслийн VI хэсгийн VI.1 зураг төслөөс (ПК73+480-ПК76+096), VI.3 зураг төсөл (Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замтай нийлэх 2 түвшний уулзвар)-ийг ашиглана.

28/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтэд Авто замын трасст орсон мэдээлэл холбооны улс хоорондын шилэн кабель шилжүүлэх, хамгаалах, угсралтын ажил туссан байна. "Арбэл-Алтай" ХХК-ний АБ\_А 15/5-21 ГХ шифртэй зураг төслийг үзнэ үү.

Ажлын зураг төслийн VI хэсгийн VI.3 зураг төсөлд (Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замтай нийлэх 2 түвшний уулзвар) нүхэн гарц туссан байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.БАТБОЛД



0000005.9